Баянгол	97.3	0.6	61.2	36.7
Багахангай	0.6	1.5	0.0	2.1
Баянзүрх	0.0	0.6	0.0	0.6
Сонгинохайрхан	9.8	0.0	2.6	7.2
Сүхбаатар	0.0	25.0	0.0	25.0
Чингэлтэй	2.2	3.3	0.6	4.9
Нийслэлийн шууд	430.7	0.0	0.0	430.7
Нийт	551.7	31.0	64.4	518.3

Төсөвт байгууллагууд сарын эхэнд 551.7 сая төгрөгийн авлагатай байснаас тайлант хугацаанд шинээр 31.0 сая төгрөгийн авлага үүсч, 64.4 сая төгрөгийн авлагыг барагдуулан сарын эцэст 518.3 сая төгрөгийн авлагатай үлджээ.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2015 оны эхний 3 сард нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 21.0 мянган байгууллагын 431.9 мянган иргэн хамрагдаж нийгмийн даатгалын шимтгэл төлжээ.

Шимтгэл төлөгч нийт иргэдийн 285.5 мянга буюу 66.1 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын, 86.4 мянга буюу 20.0 хувь нь төсөвт байгууллагын, 60.0 мянга буюу 13.9 хувь нь сайн дурын даатгуулагчид байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар буюу 17.6 мянган хүнээр нэмэгджээ.


Нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагууд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 94.9 хувиар биелүүлж, нийгмийн даатгалын санд нийт 165.1 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 63.6 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 19.0 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 7.1 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.6 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 1.9 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 23. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Зураг 24. Даатгалын сангийн зарлага



Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас энэ оны эхний 3 сард даатгуулагч, иргэдэд 202.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгожээ. Нийт зардлын 72.9 хувийг тэтгэврийн, 13.2 хувийг эрүүл мэндийн, 5.7 хувийг ҮОМШӨ-ний, 6.3 хувийг тэтгэмжийн, 1.9 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 3 дугаар сард 139.1 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 126.5 тэрбум төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 74.2 хувийг өндөр насны, 10.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.5 хувийг тэжээгчээ алдсаны, 12.1 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2015 оны 3 дугаар сарын эцэст 13860 болж, өмнөх оны мөн үеэс 20.2 хувь буюу 2334 хүнээр өсчээ. Нийт ажилгүйчүүдийн 7241 буюу 52.2 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 23. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /4-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2013 он	2014 он	2015 он	2013 он	2014 он	2015 он
Нийт ажилгүйчүүд	12027	11526	13860	100	100	100
Үүнээс: дээд боловсролтой	3967	4208	5503	33.0	36.5	39.7
Тусгай дунд боловсролтой	954	1160	1017	7.9	10.1	7.4
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	889	647	739	7.4	5.6	5.3
Ерөнхий боловсролтой	6155	5459	6527	51.2	47.4	47.1
Мэргэжилгүй	62	52	74	0.5	0.4	0.5

Зураг 25. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 20.9 хувь буюу 2893 нь 15-24 насны, 39.8 хувь буюу 5524 нь 25-34 насны, 21.2 хувь буюу 2933 нь 35-44 насны, 18.1 хувь буюу 2510 нь 45-аас дээш насны хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 16.9 хувь буюу 2344 нь Чингэлтэй, 16.3 хувь буюу 2253 нь Баянзүрх, 15.0 хувь буюу 2082 нь Баянгол, 14.5 хувь буюу 2012 нь Сүхбаатар, 13.2 хувь буюу 1830 нь Хан-Уул, 12.5 хувь буюу 1727 нь Сонгинохайрхан, 7.3 хувь буюу 1018 нь Налайх, 3.7 хувь буюу 513 нь Багануур, 0.6 хувь буюу 81 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

2015 оны 3-р сард ажилгүй 3346 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 591 иргэн ажилд зуучлагдан орж, 2961 иргэн бүртгэлээс хасагджээ. 2015 оны эхний 3 сард 11083 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 44.5 хувь буюу 3413 хүнээр өсчээ.

2015 оны эхний 3 сард 1406 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 4.0 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт, 6.2 хувь нь төсөвт байгууллагад, 89.8 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2015 оны эхний 3 сард 9943 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 111 хүүхдээр олон байна.

Нийт төрсөн хүүхдийн 12.0 хувь буюу 1194 нь бусад аймгийн харъяат эхчүүдээс төрсөн байна.

Хүснэгт 24. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, эхний 3 сард

	2013 он	2014 он	2015 он	$\frac{2015}{2014} \%$
Амаржсан эхийн тоо	9215	9740	9845	101.1
Амьд төрсөн хүүхэд	9265	9832	9943	101.1
Эхийн эндэгдэл	4	4	3	75.0
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	139	154	150	97.4
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	15.00	15.66	15.09	96.4


Нялхсын эндэгдлийн 26.9 хувь буюу 28 нь Сонгинохайрхан, 22.1 хувь буюу 23 нь Баянзүрх, 12.5 хувь буюу 13 нь Сүхбаатар, 12.5 хувь буюу 13 нь Чингэлтэй, 11.6 хувь буюу 12 нь Хан-Уул, 10.6 хувь буюу 11 нь Баянгол, 1.9 хувь буюу 2 нь Налайх, 1.9 хувь буюу 2 нь Багануур дүүрэгт тус тус гарсан байна.

Нялхсын эндэгдлийн 30.7 хувь буюу 46 нь бусад аймгийн харъяат байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 0.57 промилээр буурчээ.

Хүснэгт 25. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 3 сард

	хэмжих нэгж	2014 он	2015 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	3955	4704	749	18.9
	10000 хүнд	31.72	36.44	4.72	
Вируст гепатит	бодит тоо	130	146	16	12.3
	10000 хүнд	1.04	1.13	0.09	
Менингит	бодит тоо	2	2	-	-
	10000 хүнд	0.02	0.02	-	
Цусан суулга	бодит тоо	197	206	9	4.6
	10000 хүнд	1.58	1.60	0.02	
Салхин цэцэг	бодит тоо	650	929	279	42.9
	10000 хүнд	5.21	7.20	1.99	
Гахай хавдар	бодит тоо	59	14	- 45	- 4.2 дах
	10000 хүнд	0.47	0.11	- 0.36	
Сальмонеллёз	бодит тоо	4	9	5	2.3 дах
	10000 хүнд	0.03	0.07	0.04	
Улаан эсэргэнэ	бодит тоо	52	54	2	3.8
	10000 хүнд	0.42	0.42	-	
Улаан бурхан	бодит тоо	-	69	69	-
	10000 хүнд	-	0.53	0.53	
Хоолны хордлого	бодит тоо	23	12	- 11	- 1.9 дах
	10000 хүнд	0.18	0.09	- 0.09	
Ёлом	бодит тоо	14	25	11	1.8 дах
	10000 хүнд	0.11	0.19	0.08	
Бруцеллёз	бодит тоо	6	4	- 2	- 33.3
	10000 хүнд	0.05	0.03	- 0.02	
Нярайн халдвар	бодит тоо	2	3	1	1.5 дах
	10000 хүнд	0.02	0.02	-	
Гар хөл амны өвчин	бодит тоо	225	202	-23	- 10.2
	10000 хүнд	0.80	1.56	0.76	
Тэмбүү	бодит тоо	943	1116	173	18.3
	10000 хүнд	7.56	8.65	1.09	
Заг хүйтэн	бодит тоо	372	552	180	1.5 дах
	10000 хүнд	2.98	4.28	1.3	
Трихомониаз	бодит тоо	429	464	35	8.2
	10000 хүнд	3.44	3.59	0.15	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	672	693	21	3.1
	10000 хүнд	5.39	5.37	- 0.02	
ДОХ	бодит тоо	8	4	- 4	- 2.0 дах
	10000 хүнд	0.06	0.03	- 0.03	

Зураг 26. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар



Нийслэлд 2015 оны эхний 3 сард 4704 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 18.9 хувь буюу 749 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 4.72 продицимилээр тус тус өсчээ. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 23.7 хувийг тэмбүү, 19.7 хувийг салхинцэцэг, 14.7 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 11.7 хувийг заг хүйтэн, 9.9 хувийг трихомониаз, 4.4 хувийг цусан суулга, 4.3 хувийг гар хөл амны өвчин, 3.1 хувийг вируст хепатит өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.



НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Нийслэлийн Тээврийн газраас Улаанбаатар хотын дотор болон хот орчимд 2015 оны эхний 3 сард 4.6 мянга гаруй км урттай, 135 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулжээ.

Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд 2015 оны эхний 3 сард 238.7 сая хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, давхардсан тоогоор нийтдээ 70.2 сая хүн тээвэрлэж, 27.2 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс зорчигчийн тоо 2.2 хувиар буюу 1.6 мянган хүнээр буурч, үйлчилгээний орлого 1.7 хувиар буюу 0.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 26. Зорчигч тээврийн чиглэлийн тоо




Зураг 27. Зорчигч тээврийн чиглэлийн урт



Улаанбаатар хотод 2015 оны эхний 3 сард нийтийн тээврийн үйлчилгээг 55 аж ахуйн нэгж эрхэлсэн нь өмнөх оны мөн үеэс 11 аж ахуйн нэгжээр цөөрсөн байна. Энэ нь бүхэлдээ их, дунд, бага багтаамжийн автобусны аж ахуйн нэгжийн тоонд гарсан өөрчлөлт ажээ.

НИТХ-ын 2014 оны 8-р сарын 13-ны өдрийн 132-р тогтоолоор “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ байгуулагдаж, нийслэлийн өмчит гурван байгууллага нэгдэн үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 28. Зорчигч тээврийн үйлчилгээний ААН-ийн тоо



2015 оны эхний 3 сард бүрдүүлсэн үйлчилгээний нийт орлогын 41.8 хувийг шугамын орлого, 58.2 хувийг “нөхөн олговор”-ын орлого эзэлж байна. Нийтийн тээврээр зорчигчдын 43.7 хувь нь зорчих тасалбар худалдан авч үйлчлүүлсэн байхад 56.3 хувь нь нөхөн олговрын хөнгөлөлтөөр зорчжээ. Өөрөөр хэлбэл нийтийн тээврийн хэрэгслээр 2015 оны эхний 3 сард давхардсан тоогоор 39.6 сая зорчигч үнэ төлбөргүй үйлчлүүлж, эдгээр хүмүүсийн үйлчилгээний төлбөрт төрөөс 15.8 тэрбум төгрөгийг нөхөн олговор хэлбэрээр тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд шилжүүлсэн байна.

Хүснэгт 26. Нийтийн тээврийн үйлчилгээ, төлбөрийн хэлбэрээр, 2015 оны эхний 3 сард

Тээврийн хэрэгсэл, төрөл, өмчлөлөөр	Аж ахуйн нэгж (тоо)	Тээврийн хэрэгсэл (тоо)	Орлого (тэрбум төгрөг)	Үүнээс:		Зорчигч (сая хүн)	Үүнээс:	
				зорчих тасал-бараар	нөхөн олгов-роор		зорчих тасал-бараар	нөхөн олгов-роор
Зорчигч тээврийн нэгтгэл (ОНӨААТҮГ)	1	302	9.2	4.8	4.4	24.0	13.1	10.9
Автобус (хувийн)	19	866	17.1	5.8	11.3	43.8	15.5	28.3
Троллейбус (хувийн)	1	8	0.2	0.05	0.12	0.5	0.20	0.29
Бага, дунд багтаамжийн автобус	17	371	0.71	0.7	0.01	1.9	1.8	0.1
Дүн	38	1547	27.2	11.4	15.8	70.2	30.6	39.6

Нийслэлийн Тээврийн газраас аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан “Нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгүүлэх тухай гэрээ”-гээр насанд хүрэгчид их, дунд багтаамжийн автобусаар 500 төгрөг, цахилгаан тээврээр 300 төгрөг, туслах болон буухиа чиглэлийн бага багтаамжийн автобусаар 500-1300 төгрөг, хот орчмын чиглэлийн бүх төрлийн автобусаар 500-2300 төгрөгөөр (хүүхэд 200-1200 төгрөг) зорчиж байна. Мөн тус гэрээнд таксины үйлчилгээний нэг төлбөрт километрийн тарифыг 1000 төгрөгөөр тогтоож, үйлчилгээнд мөрдүүлэхээр заасан байна.

Зураг 29. Зорчигчдын тоо, сая хүн, төлбөрийн хэлбэрээр



Зураг 30. Үйлчилгээний орлого, тэрбум төгрөг, төлбөрийн хэлбэрээр




Хүснэгт 27. Нийтийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүний тоо

Дансны хөдлөх бүрэлдэхүүн		2014 оны эхний 3 сар	2015 оны эхний 3 сар
Бүгд		2689	2240
Их багтаамжийн автобус	Төрийн өмч	250	250
	Хувийн өмч	870	866
Бага, дунд багтаамжийн автобус (хувийн)	Туслах чиглэл	358	171
	Буухиа чиглэл	414	200
Троллейбус	Төрийн	55	52
	Хувийн	15	8
Такси		727	693


Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ нь зориулалтын 2240 хөдлөх бүрэлдэхүүнтэй ажиллажээ. Эдгээрийн 16.6 хувь нь бага, дунд багтаамжийн автобус, 49.8 хувь нь их багтаамжийн автобус, 30.9 хувь нь такси байна. 2015 оны эхний 3 сард нийтийн тээврийн парк шинэчлэлтээр их багтаамжийн 23 автобус, мөн тооны такси үйлчилгээнд шинээр нэмэгдэж, стандартын шаардлага хангахгүй болж 12-оос дээш жилээр ашиглагдаж хуучирсан 260 тээврийн хэрэгсэл (их багтаамжийн хувийн 15, бага багтаамжийн 177 автобус, 68 такси) үйлчилгээнээс хасагдсан байна.

2015 оны эхний 3 сард өдөрт дунджаар их, дунд багтаамжийн 870 автобус, 40 троллейбус, бага багтаамжийн 300 автобус, 850 такси, хот орчмын чиглэлд 70 гаруй тээврийн хэрэгсэл нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллажээ. Шугаманд өдөрт ажилласан нийт тээврийн хэрэгслийн 80.5 хувийг хувийн хэвшлийн тээврийн хэрэгсэл эзэлж байв.

Зураг 31. Өдөрт ажилласан тээврийн хэрэгсэл, тоо



Зураг 32. Хүлээлтийн хугацаа, минут




Нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлүүдийн давхцалыг арилгах арга хэмжээ авагдаж байгаа бөгөөд ихэвчлэн туслах чиглэлийн тоо багасч, туслах чиглэлд ажиллах тээврийн хэрэгслийн тоо өмнөх оны мөн үеэс нэг дахин цөөрсөн байна. Энэ нь зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу хүлээлтийн дундаж хугацаанд нөлөөлөл үзүүлээгүй байна. Өөрөөр хэлбэл нийтийн тээврийн хүлээлтийн дундаж хугацааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлт ороогүй байна.

2015 оны эхний 3 сард нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний талаар иргэдээс дараах төрлийн нийт 357 санал, гомдол Нийслэлийн Тээврийн газарт ирүүлсэний 95.2 хувийг нь шийдвэрлэж, барагдуулсан байна. Үүнд:

Зураг 33. Нийтийн тээврийн үйлчилгээний талаарх санал, гомдол, эхний 3 сард



Зураг 34. Үйлчилгээний талаар ирүүлсэн санал, гомдлын шийдвэрлэлт





ХАРИЛЦАА ХОЛБОО

Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 2015 оны эхний 3 сард 167.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.7 тэрбум төгрөгөөр буюу 2.9 хувиар өсчээ. Нийт орлогын 76.9 хувь буюу 129.0 тэрбум төгрөгийг нийслэл хотын хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс бүрдүүлсэн байна.

Хүснэгт 28. Холбооны салбарын үндсэн үзүүлэлт


	Хэмжих нэгж	2014 оны эхний 3 сар	2015 оны эхний 3 сар
Нийт орлого	сая төг	163019.5	167731.4
Үүнээс: хүн амаас	сая төг	116564.1	129056.8
Суурин телефон цэг	тоо	166555	204926
Үүнээс: айл өрхийн	тоо	136969	177269
Утасгүй телефон	тоо	576	876
Үүрэн телефон хэрэглэгч	мянган хүн	1740.2	1822.1
КаТВ-ийн хэрэглэгч	тоо	250109	294111

2015 оны эхний 3 сард нийслэлийн хэмжээнд суурин телефон цэгийн тоо 204.9 мянга болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.0 хувиар нэмэгджээ.


Нийт суурин телефон цэгийн 177.2 мянга буюу 86.5 хувийг айл өрх ашиглаж байна. Өрхийн суурин телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 29.4 хувиар өссөн нь гурвалсан үйлчилгээний суурин утасны үйлчилгээг хэрэглэгч өрхийн тоо нийслэлд өсөн нэмэгдэж байгаатай холбоотой.

2015 оны эхний 3 сард Монгол Улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 3.5 сая хүн үүрэн телефон хэрэглэж байгаагийн 51.7 хувь буюу 1.8 сая гаруй хэрэглэгч нь нийслэл хотод байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үүрэн телефон хэрэглэгчийн тоо нийслэлд 81.9 мянгаар нэмэгдсэн байна.

Зураг 35. Суурин телефон цэгийн тоо




Зураг 36. Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо



Үүрэн холбооны нийт хэрэглэгчдийн 260.9 мянга нь дараа төлбөрт үйлчилгээний, 1561.2 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна. Хөдөлгөөнт утасгүй телефон буюу WLL үйлчилгээний хэрэглэгчдийн тоо 0.8 мянга болж буурсан нь F-zone үйлчилгээний хэрэглэгчдийг CDMA болон GSM системд шилжүүлэх техникийн зохицуулалт хийгдэж ирсэнтэй холбоотой. Нийслэлд 0.7 мянган хэрэглэгч сансрын холбоог эзэмшиж байна.

2015 оны эхний 3 сард кабелийн телевизийн үйлчилгээг 18 аж ахуйн нэгж нийслэлийн 294.1 мянган хэрэглэгчдэд хүргэжээ. Кабелийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн 94.8 хувийг айл өрх эзэлж байна.

Зураг 37. КаТВ, сувагт холбогдсон хэрэглэгчийн тоо



Кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт аж ахуйн нэгжийн 16 нь нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж, хоногт дундажаар 50-110 гаруй сувгаар үйлчилгээ хүргэсэн байна. Нийслэлийн Налайх, Багануур дүүргийн хэрэглэгчдийн хувьд 49-63 хүртэл сувгаар кабелийн телевизийн үйлчилгээг хүлээн авч байна.

Гурвалсан үйлчилгээнээс бусад кабелийн телевизийн сувагт холбогдох шинэ тавилтын үнэ нийслэлийн төвийн 6 дүүргийн айл өрхөд 10.0-100.0 мянган төгрөгийн хооронд байхад үйлчилгээний төлбөрийн сарын хураамж өрхөд 4000-11000 төгрөгийн тарифтай байв.



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж температур 2015 оны 3-р сард дунджаар -6.2°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс -2.5°C -аар, олон жилийн дундажтай харьцуулахад -1.5°C -аар тус тус хүйтэн байлаа.

Энэ сард үнэмлэхүй их температур 17.5°C , үнэмлэхүй бага температур -22.4°C , хур тунадасны нийлбэр 20.5 мм, салхины үнэмлэхүй их хурд 14 м/секунд хүрч, шороон болон цасан шуургатай 1 тохиолдлыг бүртгэжээ.


Хүснэгт 29. Агаарын бохирдолт, $\text{мг}/\text{м}^3$

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хийсэн ажиглалтын тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдол /тоо/	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO_2	0.020	267	0.126	186	0.036
Азотын давхар исэл	NO_2	0.040	292	0.081	133	0.039
Тоосжилт	PM_{10}	0.100	294	0.621	171	0.143
	$\text{PM}_{2.5}$	0.050	178	0.229	112	0.080
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.000	814	9.471	-	1.124
Озон	O_3	0.100	272	0.078	-	0.025


*- Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2015 оны 3-р сард Улаанбаатар хотын 13-р хороолол орчимд 31 удаа, Баруун дөрвөн зам орчимд 29 удаа, 32-ын тойрог орчимд 23 удаа, Телевиз орчимд 20 удаа, 1-р хороолол орчимд 13 удаа, Толгойт орчимд 8 удаа, Амгалан орчимд 6 удаа, Офицеруудын ордон орчимд 2 удаа, Ургах наран хороолол орчимд 1 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж Амгалан орчимд 31 удаа, Телевиз орчимд 30 удаа, 32-ын тойрог орчимд 29 удаа, Толгойт орчимд 27 удаа, Баруун дөрвөн зам орчимд 23 удаа, 13-р хороолол орчимд 22 удаа, Мишээл экспо төвийн орчимд 13 удаа, Хархорин зах орчимд 11 удаа давжээ.


Зураг 38. Хүхэрлэг хийн агууламж, мг/м³



Зураг 39. Азотын давхар ислийн агууламж, мг/м³




Зураг 40. Тоосны /PM₁₀/ агууламж, мг/м³



10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгойт орчимд 29 удаа, 32-ын тойрог болон Телевиз орчимд тус бүр 28 удаа, Амгалан орчимд 21 удаа, Баруун дөрвөн зам орчимд 18 удаа, Хархорин зах орчимд 15 удаа, 13-р хороолол болон Нисэх орчимд тус бүр 14 удаа, Мишээл экспо төвийн орчимд 3 удаа, Ургах наран хороолол орчимд 1 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгойт болон Телевиз орчимд тус бүр 30 удаа, Амгалан орчимд 21 удаа, Нисэх орчимд 16 удаа, 13-р хороолол орчимд 8 удаа, Баруун дөрвөн замын орчимд 7 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Зураг 41. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м^3



Туул голын усны найрлага Туул-Налайх, Туул-Зайсан харуул цэгийн орчимд хэмжилт хийгдээгүй, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгчийн хэмжээ горим алдагдаж онцгой их бохирдолтой, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 75.8 дахин, амоны азот 77.0 дахин, нитридийн нэгдэл 2.3 дахин, эрдэс фосфор 23.0 дахин хүлцэх хэм хэмжээнээс хэтэрч Туул голын ус маш бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 30. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м^3 , 3-р сард

	Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O_2)	≥ 6	Хэмжилт хийгдээгүй		0.05	онцгой их бохирдолтой
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ_5)	≤ 3			227.5	75.8 дахин
Нитридийн нэгдэл (NO_2)	≤ 0.02			0.046	2.3 дахин
Амоны азот (NH_4)	≤ 0.5			38.51	77.0 дахин
Эрдэс фосфор (P)	≤ 0.1			2.300	23.0 дахин

*- Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

Хүснэгт 31. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, 3-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруу- дын ордон	Хархорин зах	Ургах наран хороолол	Нисэх	Толгойт	Телевиз	Амгалан
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.018	0.033	-	0.031	0.037	-	0.018	-	0.012	0.049	0.065	0.058
	Хамгийн их	0.031	0.057	-	0.053	0.060	-	0.033	-	0.018	0.074	0.126	0.112
	XXX*-с давсан хувь	45	79	-	71	94	-	36	-	-	100	97	100
	Хэмжилтийн тоо	29	29	-	31	31	-	31	-	27	27	31	31
Азотын давхар Исэл NO ₂	Дундаж	-	0.071	0.039	0.061	0.046	0.029	-	0.025	0.017	0.033	0.041	0.031
	Хамгийн их	-	0.081	0.074	0.079	0.060	0.065	-	0.041	0.023	0.048	0.055	0.046
	XXX*-с давсан хувь	-	100	46	100	74	8	-	4	-	26	65	19
	Хэмжилтийн тоо	-	29	28	31	31	25	-	28	27	31	31	31
Нүүрс- төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	-	1.489	-	1.010	0.469	-	0.831	0.394	0.819	1.933	2.411	0.760
	Хамгийн их	-	3.338	-	3.725	2.400	-	3.425	1.625	2.351	5.251	9.471	4.241
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	89	-	93	93	-	93	86	81	93	93	93
Тоос PM10	Дундаж	0.064	0.108	-	0.117	0.196	-	0.119	0.047	0.115	0.282	0.240	0.139
	Хамгийн их	0.123	0.210	-	0.217	0.330	-	0.245	0.130	0.207	0.621	0.474	0.257
	XXX*-с давсан хувь	10	60	-	48	90	-	48	5	52	94	90	68
	Хэмжилтийн тоо	31	30	-	29	31	-	31	22	27	31	31	31
Тоос PM2.5	Дундаж	-	0.043	-	0.045	-	-	-	-	0.058	0.148	0.121	0.065
	Хамгийн их	-	0.078	-	0.125	-	-	-	-	0.116	0.229	0.229	0.125
	XXX*-с давсан хувь	-	24	-	28	-	-	-	-	59	97	97	68
	Хэмжилтийн тоо	-	29	-	29	-	-	-	-	27	31	31	31
Озон O ₃ **	Дундаж	-	-	-	0.017	0.011	-	-	0.047	-	-	-	-
	Хамгийн их	-	-	-	0.038	0.023	-	-	0.078	-	-	-	-
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	-	93	93	-	-	86	-	-	-	-

* - Хүлцэх хэм хэмжээ, ** - CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон.

Байгаль орчны зөрчил Нийслэлд 2015 оны эхний 3 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 82 зөрчлийг илрүүлжээ. Нийт зөрчлийн 54.9 хувийг газрын зөрчил, 11.0 хувийг ойн зөрчил, 11.0 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 7.3 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 4.9 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 10.9 хувийг бусад зөрчлүүд эзэлж байна.

Илрүүлсэн нийт зөрчилд 2.1 сая төгрөгийн торгууль ногдуулж, ойн зөрчил гаргасан иргэдээс 99.0 мянган төгрөгийн эд зүйлс хураан авчээ.

Хүснэгт 32. Байгаль орчны зөрчил, төрлөөр, оны эхний 3 сард

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2014 он			2015 он		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /мян.төг/
Ой	2	-	-	2	9	960.0
Ан, амьтан	-	-	-	2	3	-
Газрын	-	-	-	1	1	-
Ус	-	-	-	6	45	-
Ургамал, хөрсний бохирдол	-	-	-	1	4	-
Агаар, химийн хорт бодис	-	-	-	9	9	1152.0
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	-	-	-	6	6	-
Геодези зураг зүй, кадастр	5	2	200.0	3	3	-
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	-	-	-	3	2	-
Бусад	1	1	384.0	1	-	-
Бүгд	8	3	584.0	34	82	2112.0



ХОТ ТОХИЖИЛТ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2015 оны эхний 3 сард Баянгол, Чингэлтэй, Налайх дүүрэгт 408.7 мянган м² талбайн зүлэг, 19488 ширхэг мод, 5356 ширхэг сөөгийг арчилж тордон, 167.5 сая төгрөгийн ажил гүйцэтгэжээ.

Хүснэгт 33. Тээвэрлэсэн хог, мянган тонн, дүүргээр

Дүүрэг, бусад байгууллагууд	Тээвэр- лэсэн хог	хог, бүтцээр					
		Орон сууц	Гэр хороолол	Албан байгууллага	Зам талбай	Хур хог	Бохир шингэн
Багануур	2.4	0.9	1.2	0.2	0.1	-	-
Баянгол	31.7	12.4	6.0	10.9	2.4	-	-
Баянзүрх	10.3	1.4	3.1	5.0	0.7	0.1	-
Налайх	18.1	3.5	12.3	1.5	0.8	-	-
Сонгинохайрхан	49.2	5.1	25.0	13.9	5.1	0.1	-
Сүхбаатар	9.2	4.4	2.1	2.1	0.6	-	-
Хан-Уул	35.4	5.4	10.3	17.5	2.1	0.1	-
Чингэлтэй	24.3	2.5	19.7	1.6	0.5	-	-
Дүн	180.6	35.6	79.7	52.7	12.3	0.3	-

Багануур, Баянгол, Чингэлтэй дүүргүүд хотын нийтийн эзэмшлийн 3247.7 метр урт хайс хамгаалалт, 1 автобусны зогсоол, 29 хогийн сав, 21 сандлыг засварлаж энэ ажилд 48.5 сая төгрөгийг зарцуулав. Мөн хотын орон сууцны хороололд 4.2 км, гэр хороолол орчимд 6.0 км урт гэрэлтүүлэг хийж 606.1 сая төгрөг зарцуулсан бөгөөд гэрэлтүүлгийн асалт дунджаар 94.8 хувь, хотын рекламны асалт 92.4 хувьтай байлаа.

Хог цэвэрлэгээний ажлаар 10794.0 мянган м² зам талбайг цэвэрлэж, 180.6 мянган тонн хог тээвэрлэж, Нарангийн энгэр, Морин даваа, Цагаан даваанд төвлөрсөн хогноос 160.1 мянган тонн хогийг дарж устгав. Дарж устгасан хогны 18.7 хувийг орон сууцны хороолол, 40.6 хувийг гэр хороолол, 33.9 хувийг аж ахуйн нэгж байгууллага, 6.8 хувийг зам талбайн хог эзэлж байна.


Дүүргүүдийн тохижилт үйлчилгээний байгууллагууд 2015 оны эхний 3 сард 17868 золбин нохойг устгаж, энэ ажилд 104.1 сая төгрөг зарцуулав.




ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн хүн амд 2015 оны эхний 3 сард 8.7 сая м³, аж ахуйн нэгж, байгууллагад 2.9 сая м³ цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан усны нийт хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 1.4 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 42. Борлуулсан ус, сараар, мян.м³



Зураг 43. Татан зайлуулсан бохир, сараар, мян.м³



Хүснэгт 34. Ус суваг ашиглалтын үйлчилгээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014 он III сар	2015 он III сар	$\frac{2015}{2014}\%$
Шахсан ус	мян.м³	13832.0	13172.1	95.2
Борлуулсан ус	мян.м³	11434.8	11595.8	101.4
Хүн амд	мян.м³	8463.6	8651.2	102.2
ААНБ-д	мян.м³	2971.2	2944.6	99.1
Татан зайлуулсан бохир	мян.м³	11122.2	11373.9	102.3
Хүн амаас	мян.м³	7828.6	8052.1	102.9
ААНБ-аас	мян.м³	3293.6	3321.8	100.9
Ус борлуулалтын орлого	сая төг	4049.7	6757.5	166.9
Хүн амаас	сая төг	2375.6	3962.4	166.8
ААНБ-аас	сая төг	1674.1	2795.1	167.0
Сувагжуулалтын орлого	сая төг	2259.8	4086.9	180.9
Хүн амаас	сая төг	1153.1	1790.9	155.3
ААНБ-аас	сая төг	1106.7	2296.0	207.5

Нийт борлуулсан усны 75.8 хувийг хүн амд, 24.2 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан ус эзэлж байна.

Хүн амд түгээсэн цэвэр усны 96.5 хувь буюу 8347.0 мян.м³ усыг төвлөрсөн шугамаар, 301.3 мян.м³ усыг ус түгээх байраар, 2.9 мян.м³ усыг тээврээр түгээсэн байна.

Цэвэрлэх байгууламжаар 13.9 сая.м³ бохир цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 11.4 сая.м³ бохир шингэнийг татан зайлуулсан байна.



ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2015 оны эхний 3 сард нийт 104 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар буурсан байна. Нийт гамшиг ослын 103 нь хүний үйл ажиллагаатай холбоотой осол, харин 1 тохиолдол нь гахайн үржил-амьсгалын замын хам шинж өвчин байв.

Хүний үйл ажиллагаатай холбоотой сум галт хэрэгслийн 1, химийн бодисын 5, бичил уурхай, нурангины 2, бусад 95 осол гарсан байна. Ослоос 72 хүнийг аварч, ослын уршгийг арилгах ажилд нийт 1.2 сая төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 35. Гал түймрийн тоо, дүүргээр

Дүүрэг	2014 он	2015 он	$\frac{2015}{2014}\%$
Бүгд	855	896	104.8
Багануур	7	8	114.3
Багахангай	-	3	-
Баянгол	135	119	88.1
Баянзүрх	214	235	109.8
Налайх	37	26	70.3
Сүхбаатар	114	109	90.0
Хан-уул	91	77	95.6
Чингэлтэй	89	113	127.0
Сонгинохайрхан	168	206	122.6

Нийслэл хотод 2015 оны эхний 3 сард ой хээрийн 2 түймэр, ахуйн 896 гал түймэр гарчээ. Ахуйн гал түймэр өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар нэмэгдсэн байна.


Гал түймрийн 8 нь Багануур, 3 нь Багахангай, 119 нь Баянгол, 235 нь Баянзүрх, 26 нь Налайх, 109 нь Сүхбаатар, 77 нь Хан-Уул, 113 нь Чингэлтэй, 206 нь Сонгинохайрхан дүүрэгт тус тус гарсан байна.

Гал түймрийн улмаас 13 хүн (үүнээс, хүүхэд 2) амь насаа алдаж, 6 хүн (үүнээс, хүүхэд 2) түлэгдэж гэмтжээ. Гал түймрийн аюулаас 145 хүн, 473 байшин


барилга, 2.6 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварчээ.

Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилвал цахилгаанаас 188, санамсаргүй байдлаас 597, шалтгаан тогтоогдоогүй 103, бусад шалтгаанаар 8 гал түймэр гарсан байна. Гал түймэрт 364 гэр, орон сууц, 28 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 52 машин техник, бусад 452 объект өртсөн байна. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 586, төрийн өмчийн 258, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 51, гадаад улсын хөрөнгө оруулалттай 1 объект өртөж, нийт 5.8 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Зураг 44. Гал түймэр, шалтгаанаар



Зураг 45. Гал түймэр, байршлаар



Нийслэлийн Онцгой байдлын газраас 2015 оны эхний 3 сард 54 барилгын зураг төсөл, ашиглалтанд хүлээн авч буй 150 барилгад хяналт тавьж ажиллажээ. Мөн 5697 айл өрх, 2931 объектод үзлэг шалгалт хийж, 15346 галын зөрчил илрүүлж, 73 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 851 заавал биелүүлэх албан шаардлага, 964 мэдэгдэл хүргүүлж, 19.5 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.



ГЭМТ ХЭРЭГ

2015 оны эхний 3 сард 5069 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 23.6 хувь буюу 968 хэргээр өсчээ.

Гэмт хэргийн илрүүлэлт 53.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр дээгүүр байна.

Зураг 46. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Гэмт хэргийн улмаас 1747 хүн гэмтэж осолдож, 165 хүн нас барж, төр ард иргэдэд 39.6 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 13.1 хувь буюу 5.2 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 32.4 хувийг хулгайн, 24.4 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 9.9 хувийг залилан, 7.4 хувийг танхайн, 5.9 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 36. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр, эхний 3 сард

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2014 он	2015 он	Тоо	Хувь
Хүний амь	29	28	- 1	- 3.4
Хүчин	40	31	- 9	- 22.5
Дээрэм	176	143	- 33	- 18.8
Хулгай	1278	1643	365	28.6
Булаалт	52	59	7	13.5
Залилан	314	502	188	1.6 дах
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	1095	1238	143	13.1
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	218	301	83	38.1
Бусдыг амиа хорлоход хүргэх	139	121	- 18	- 12.9
Ашиглах	44	59	15	34.1
Танхайрах	328	377	49	14.9
Бусад	388	567	179	46.1
БҮГД	4101	5069	968	23.6

Хүснэгт 37. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр, эхний 3 сард

дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2014 он	2015 он	Тоо	Хувь
Багануур	68	82	14	20.6
Багахангай	3	5	2	1.7 дах
Баянгол	657	799	142	21.6
Баянзүрх	994	1308	314	31.6
Налайх	90	130	40	44.4
Сонгинохайрхан	707	841	134	19.0
Сүхбаатар	629	896	267	42.4
Чингэлтэй	607	665	58	9.6
Хан-Уул	346	343	- 3	- 0.9
ДҮН	4101	5069	968	23.6

Хүснэгт 38. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2015 оны эхний 3 сард


дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс: сэжигтнийг илрүүлж ял сонгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
Багануур	18	9	50.0
Багахангай	0	0	-
Баянгол	306	208	68.0
Баянзүрх	741	337	45.5
Налайх	33	21	63.6
Сонгинохайрхан	528	315	59.7
Сүхбаатар	544	255	46.9
Чингэлтэй	398	204	51.3
Хан-Уул	153	101	66.0
ДҮН	2721	1450	53.3

Хүснэгт 39. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 3 сард

дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2014 он	2015 он	2014 он	2015 он
Багануур	13	15	12	12
Багахангай	1	-	-	-
Баянгол	179	187	139	150
Баянзүрх	365	458	328	383
Налайх	13	24	10	20
Сонгинохайрхан	240	325	224	300
Сүхбаатар	200	330	145	236
Чингэлтэй	178	228	165	187
Хан-Уул	89	76	77	72
ДҮН	1278	1643	1100	1360

2015 оны эхний 3 сард хүнд хэрэг 360, онц хүнд хэрэг 92, хүндэвтэр хэрэг 2215, хөнгөн хэрэг 2402 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5.6-31.9 хувиар өсчээ.

Зураг 47. Гэмт хэргийн тоо, ангиллаар



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 3581 болж, 2014 оны мөн үеэс 21.4 хувь буюу 631 хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 12.3 хувь буюу 439 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 16.3 хувь буюу 584 нь согтуугаар үйлдсэн, 5.2 хувь буюу 186 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 3.3 хувь буюу 118 нь хүүхэд, 17.7 хувь буюу 634 нь эмэгтэйчүүд байна.

2015 оны эхний 3 сард 14676 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 16.7 хувь буюу 2945 хүнээр буурсан байна.